

УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ.

“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН  
ГАЗРЫН ДАРГА

ТАВАНТОЛГОЙ  
ҮЙЛДВЭРЛЭЛ

ЧАЛТАНСҮХ

“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК -ИЙН ЗҮҮН ҮЙЛДВЭРИЙН 3.5 КМ САЙЖРУУЛСАН  
ШОРООН ЗАМЫГ АСФАЛЬТАН ХУЧИЛТТАЙ БОЛГОХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 08 сарын 15 өдөр

Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулж, асфальтан зам барих ажлын үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>2022.02.22-ны орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны албан даалгавар;</li><li>“Тавантолгой түлш” ХХК -ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө</li><li>Ажилчдын зорчих хэсгийн аюулгүй байдлыг хангах</li><li>Орчны тоосжилтыг бууруулах</li></ul>
2. Эзэмшигчийн нэр, авто замын байршил, хэмжээ	Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг, Баян уулын баруун тал, “Тавантолгой түлш” ХХК -ын зүүн үйлдвэр
3. Дагаж мөрдөх замын төлөвлөлт	Налайх- Чойрын А0101 улсын чанартай авто замаас “Тавантолгой түлш” ХХК -ын зүүн үйлдвэрийн 1-р харуулын пост хүртэлх 3.5км урттай сайжруулсан шороон замыг стандартын дагуу асфальтан хучилттай болгох
4. Авто зам, замын байгууламжийн ангилал	3-р зэргийн улсын чанартай зам
5. Хийц, бүтээц	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, нормативт нийцүүлэх
6. Авто замын бүрэлдэхүүн: – Авто замын зурvas хэсэг – Зорчих хэсэг	Төв замаас Зүүн үйлдвэр хүртэл авто замын хучилтын өргөн 7метр, 2 эгнээтэй байна. Ажлыг гүйцэтгэхдээ нийт ажилчид саадгүй зорчих хөдөлгөөний зориулалттай түр зам гарц хийж гүйцэтгэх

7. Боловсруулахад ашиглах материал	<p>Монгол улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль</li> <li>- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД/30.01.01/-ийн дагуу төлөвлөх</li> <li>- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт</li> <li>- Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5345:2011</li> <li>- Авто замын дагуу чиглэлд хучилтын тэгш бус байдлын олон улсын индексийг тооцоолох практик арга MNS ASTM E1926 : 2008</li> <li>- Авто замын тэмдэг болон дохионы төмөр бетон шон. Техникийн шаардлага MNS 4912:2016</li> <li>- Авто замын төмөр хашлага. Техникийн шаардлага MNS 5614: 2006</li> <li>- MNS 4699 : 2016 Зам талбайн хучилтын бетон хавтан. Техникийн шаардлага</li> <li>- MNS 2228 : 2019 Угсармал бетон, төмөр бетон бүтээц эдлэхүүн. Техникийн ерөнхий шаардлага</li> </ul>
8. Замын байгууламж	<ul style="list-style-type: none"> <li>- Буталсан чулуун суурь 20см</li> <li>- Суурь асфальт 4см</li> <li>- Өнгө асфальт 3см</li> </ul>
9. Ерөнхий шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>• Нийт замын урт: 3,5км</li> <li>• Тооцоот хурд: 30-50км/цаг.</li> <li>• Зорчих хэсгийн өргөн 7м. 2 эгнээ</li> <li>• Зорчих хэсгийн хөндлөн хэвгий: 2%</li> <li>• Хөвөөний өргөн: 2,0метр x2 Хөвөөний 0,5м хэсэг нь АБ бэхэлгээтэй.</li> <li>• Хөвөөний хөндлөн хэвгий: 4%</li> <li>• Хурд сааруулагч: Нийт замын уртад бш доошгүй хурд сааруулагч захиалагч талтай зөвшилцэн хийх</li> <li>• Эргэлттэй замын хэсгүүдэд цацуулагч авто замын төмөр хашлага 3ш доошгүй газар 60м-ээс доошгүй хийж сууринуулах</li> </ul>
10. Зураг төслийн бүрдэл (Байр зүйн дэвсгэр зураг, инженер-геологийн дүгнэлт, байгаль экологийн дүгнэлт зэрэг тухайн барилгын төлөвлөлтийн онцлогтой уялдсан бусад дүгнэлт,	Налайх- Чойрын А0101 улсын чанартай авто замаас “Тавантолгой түлш” ХХК -ын зүүн үйлдвэрийн 1-р харуулын пост хүртэлх 3.5км урттай сайжруулсан шороон замыг

судалгаа, төсөв зэрэг зургийн бүрдэлд хамрагдах ажлыг бичнэ)	стандартын дагуу асфальтан хучилттай болгох
11. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай. Гэрээт хугацаанд хийж гүйцэтгэх Ажлын зургыг эрх бүхий компаниар батлуулах Зураг төслийг гүйцэтгэх явцад захиалагч талтай зөвшилцэх
12. Барилга байгууламжийн угсралт гүйцэтгэх байгууллага	Туслан гүйцэтгэгч
13. Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	"Тавантолгой түлш" ХХК
14. Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>Монгол улсын болон олон улсын стандарт, аюулгүй ажиллагаа, хот төлөвлөлтийн дүрэм, шаардлага, барилга авто замын салбарт мөрдөгдөж буй монгол улсын үндэсний стандартууд норм дүрэм хангасан байх</li> <li>Ажлын явцад зураг төсөл, тоног төхөөрөмжийн хэмжээтэй холбоотойгоор өөрчлөлтүүд гарч болно.</li> </ul>
15. Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон зөвшөөрөгдсөн бусад программаар мэргэжилийн эрх бүхий төсөвчин тооцоолол хийх



ТАНИЛЦСАН:

ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Н.БАЛДАН-ОСОР

ХЯНАСАН:

ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.БОЛД-ЭРДЭНЭ

ЗҮҮН ҮЙЛДВЭРИЙН ДАРГА

 Г.БАТТӨМӨР

ЗҮҮН ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 М.МОНХБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

БАРИЛГЫН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

 Н.САЙХАНБАЯР